

Батлав:
“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П.ГАНХҮҮ

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НОГООН НУУР СУМЫН НУТАГТ ОРШИХ АСГАТЫН МӨНГӨНИЙ
ОРДЫН АШИГЛАЛТЫН УЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ: УУРХАЙН
ХЭВТЭЭ АМНУУДЫГ НЭЭХ, НЭВТРЭХ, ДАЛД МАЛТАЛТУУДААС ТЕХНОЛОГИЙН
ДЭЭЖ БЭЛТГЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

ҮНИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ УРИЛГА

2019.10.11

Тендер шалгаруулалтын нэр: Асгатын мөнгөний ордын ашиглалтын үйл ажиллагааг явуулах бэлтгэл ажил: Уурхайн хэвтээ амнуудыг нээх нэвтрэх далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар: ЭМГЛ/201901017

“Эрдэнэс Монгол” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Асгатын мөнгөний ордын хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцохын тулд эргэж төлеигдөхгүй нөхцөлтэйгээр 0 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 28 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон ажлын туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь төсөөт өртгөөс багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил буюу “2017, 2018”

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Тийм.

Тусгай зөвшөөрлийн нэр:

Авто зам, замын байгууламжийг барих засварлах

Тендерт оролцогч нь тендерийн хамт захиалагчийн төсөөт өртгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөг (эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валют)-ийн дунтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр 2019 оны 10 дугаарр сарын 17-н өдрийн 11:00 цагаас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлуулан тендерийг 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 11:10 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх “эрхгүй”.

Дотоодын давуу эрх “тооцохгүй”.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг,
14-р давхар Утас: 75553399-215

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> |
| 3. Тендерийн иж бүрдэл | <p>3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <p>(а) Үнийн санал;</p> <p>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;</p> <p>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</p> <p>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</p> <p>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</p> |
| 4. Тендерийн үнэ | <p>4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.</p> <p>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.</p> <p>4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> |
| 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | <p>5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| 6. Алдааг залруулах | <p>6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> |

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Аж ахуй нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.</p> <p>2. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан. /2017, 2018 он/</p> <p>3. Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого төсөвт өртөгөөс багагүй байх.</p> <p>4. Харьяалагдах татварын цахим тайлангийн системээс авсан тодорхойлолт;</p> <p>5. Харьяа дүүргийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт /өр төлбөргүй тухай/;</p> <p>6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт;</p> <p>7. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;</p> <p>8. Харилцагч банкнуудын хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаарх тодорхойлолт;</p> <p>9. Харьяалагдах банк, татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас тодруулга хүсэхэд татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг.</p> <p>10. Онцгой байдлын харьяа Уул уурхайн аврах ангитай хамтаран ажиллах гэрээ хийсэн бол давуу талтай.</p> <p>11. Тендерийн баталагаа төсөв өргтийн 1 хувьтай тэнцэх мөнгөн дүн байршуулах.</p> <p>Жич: ТШӨХ-д заасан баримт бичгүүдийн аль нэгийг ирүүлээгүй, эсвэл тэдгээр нь хүчингүй, зохих шаардлага хангаагүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 10 дугаар сарын 17-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 10 сарын 17-ний өдөр</p> <p>Цаг: 11 цаг 10 минутад</p> <p><i>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь төрийн худалдан авах ажислаагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө өөрчлөлт оруулах эрхтэй.</i></p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрднэ. Тендерийн нэр: Баян-өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Асгатын мөнгөний ордын ашиглалтын үйл ажиллагааг явуулах бэлтгэл ажил: Уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малтaluудаас технологийн дээж бэлтгэх.</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Асгатын мөнгөний ордын үйл ажиллагааг явуулах бэлтгэл ажил: Уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх тендерийн техникийн даалгавар

1. ОРШИЛ

Монгол Улсын засгийн газраас 2019 оны 01 дүгээр сарын 16-ний өдөр Асгатын мөнгөний ордыг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах бэлтгэл ажлыг хангах шийдвэрийг гаргаж, 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр албан ёсоор шилжүүлэн авсан. Асгатын мөнгө, холимог металлын орд нь Монгол орны баруун хойд хэсэгт, Баян-Өлгий аймгийн Ногоон-нуур сумын нутагт Улаанбаатар хотоос 1800км, Өлгий хотоос 180км зайдай оршдог. Далайн төвшинөөс дээш +3000 метр өндөрт байрлах бөгөөд 2880-3180 метр төвшинд хүдрийн биетийн ихэнх хэсэг байрладаг. Тус бус нутаг нь цаг уурын эрс тэс уур амьсгалтай хур тунадас их унадаг. Агаарын жилийн дундаж температур 0 хэм. Байнгын цахилгаан эрчим хүч байхгүй бөгөөд ордоос 70 км зайднд Ногооннуур сум дээр 35 кВт-ын агаарын шугам ирсэн. Тус орд газарт 1987-1992 онуудад ордын 1 болон 2 дугаар судлын бүсэд далд малталтын аргаар нарийвчилсан хайгуулын ажил хийж 1996 оны 04 дүгээр сард хүдрээр 6415.3 мянган тонн, металл-мөнгөний 2253.8 тонн, зэсийн 72649.8 тонн, сурьмаагийн 32131.1 тонн, висмутын 3287.5 тонн, жишмэл мөнгөний 2643.0 тонн нөөцийг C1+C2 зэргээр батлуулсан. 1998 онд ОХУ-ын Новосибирскийн судалгаа шинжилгээ, төслийн “Сибгипрозолото” институттэй гэрээ байгуулан ТЭЗҮ-ийг хийлгэсэн. Тооцоонд үйлдвэрийн жилийн хүдэр олборлох хүчин чадлыг 600 мянган тонн ба 350 мянган тонн гэсэн 2 хувилбараар авч хувилбар тус бүр дээр гаргах баяжмалыг хам ба салангид баяжмал гэсэн хувилбаруудаар авч эдийн засгийн тооцоог хийсэн байдал. Үүнээс хойш Асгатын мөнгөний орд газарт геологи хайгуул, судалгаа шинжилгээний ажил бараг хийгдээгүй юм.

2. ҮНДЭСЛЭЛ

- Орд газарт нэвтэрсэн 1-5 дугаар хэвтээ далд малталтууд нь олон жилийн турш цасан нурангид дарагдаж, 150-200 метр орчим мөстөж хүн болон техник хэрэгсэл нэвтрэх боломжгүй болсон.
- Орд газарт хүрэх зам үерийн усны нөлөөгөөр эвдрэл гэмтэлд орж машин техник, тоног төхөөрөмж зорчиход хүндрэлтэй болсон.
- Далд малталтуудыг холбосон технологийн зам хад асга нурангид дарагдаж машин техник зорчих боломжгүй болсон.
- Орд газарт 1998 оноос хойш судалгаа шинжилгээний хийгдээгүй, тухай үед хийгдсэн технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилт нь хангалтгүй.

3. АЖЛЫН ЗОРИЛГО

Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах бэлтгэл ажлыг хангах: Уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх техник, тоног төхөөрөмж хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх.

4. СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТАЛБАЙ

Баян-Өлгий аймаг, Ногооннуур сум Асгатын мөнгөний орд газарт

5. АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

- Орд газарт хүрэх замын эвдрэл гэмтэлтэй хэсгийг засварлах машин, техник тоног төхөөрөмж хэвийн саадгүй зөрчих боломжтой болгох.
- Далд малталтуудын ам хоорондын технологийн замыг машин, техник тоног төхөөрөмж хэвийн саадгүй зорчих боломжтой болгох.
- Далд малталтуудын орц хэсгийг тагласан мөсийг зайлцуулах. /1-5 дугаар хэвтээ далд малталт/
- Нээгдсэн хэвтээ амнуудыг ахин цасан нурангид дарагдахаас хамгаалж хаалт, бэхэлгээ хийх.

- Далд малтaluудаас ордыг төлөөлхүйц технологийн дээж бэлтгэх. /20 тонн/
- Технологийн дээжийг зориулалтын уутанд савлах, Улаанбаатар хот руу тээвэрлэж, хадгалах агуулахад байршуулах.

6. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Орд газарт хүрэх замаар саадгүй зөрчих боломж бүрдэнэ.
- Далд малтaluудын ам хооронд машин, техник хэвийн зөрчих боломжтой болно.
- Хэвтээ малтaluудаар саадгүй хэвийн нэвтрэх боломж бүрдэнэ.
- Технологийн дээж авч лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилт хийлгэх боломжтой болно.

7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Гэрээ байгуулснаас хойш 60 хоног

8. ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага:

- Орд газрын уул геологи, уул техник, цаг уурын хүндрэлтэй нөхцөлөөс шалтгаалан үүсэж болзошгүй эрсдэл, байгалийн давагдашгүй хүчин зүйл зэргээс урьдчилан сэргийлэх, далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, журмын дагуу зайлшгүй иж бүрэн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон уул уурхайн аврах ангитай байх.
- Эсхүл Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Уул уурхайн аврах ангитай хамтран ажиллах. /Гэрээ хэлэлцээр хийсэн байх/.
- Уулын зам гүүр засварлаж байсан мэргэжлийн туршлагатай тусгай зөвшөөрөлтэй компани байх.

Техник, тоног төхөөрөмжийн шаардлага:

- Дээж тээвэрлэх машин-1ш /20 тонн түүнээс дээш даацтай байх/.
- Хийн компрессор болон гар молоток-5ш /хүдрийн дээж авах хүчин чадалтай байх/.
- Далд малтaluыг агааржуулах хоолой бүхий вентелятор /500 метрээс дээш урттай хэвтээ малтaluыг агааржуулах/
- Далд малтaluыг гэрэлтүүлэх зөөврийн төхөөрөмж /500 метрээс дээш урттай хэвтээ малтaluыг гэрэлтүүлэх/
- 220В болон 380В-ын зөөврийн цахилгаан үүсгүүртэй байх.
- Малтaluын амнуудад хаалт хийх иж бүрэн багаж хэрэгсэлтэй байх. /Гагнуурын аппарат, таслагч, өрөм гэх мэт/.
- Дээж савлах зориулалтын дээжний ууттай байх.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарь заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өргтийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцуулэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮННИЙ САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдолыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдолыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ	
11. Үе шатны ажлын хуваарь	11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх	11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
13. Алданги	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
14. Ажил дуусгах	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнэ. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ	
15. Хүлээж авах	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
16. Эцсийн тооцоо	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлагы	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
18. Гүйцэтгэгчийн тооцоо	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ec. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Гэрээний нэр: Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Асгатын мөнгөний ордын Гэрээний дугаар:
ГЕН 2.1	Ажил нь: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн өөрийн хөрөнгөөр Ажлын нэр: Баян-өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Асгатын мөнгөний ордын ашиглалтын үйл ажиллагааг явуулах бэлтгэл ажил: Уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр /Гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор/ Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр /Гэрээ байгуулснаас хойш 2 сар/
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [too] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0.1] байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10] байна.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧI

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
<i>П.Ганхүү</i>	
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож өдөр энэхүү АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь (цаашид “ажил” гэх) (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Өөрийн хөрөнгө: 2019 онд: төгрөг

4. Гүйцэтгэгч нь Асгатын мөнгөний орд хүрэх зам талбайг засварлах, машин, техник хэвийн зорчих нөхцөлийг бүрдүүлэх, уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх боломжтой болгох, ахин нурангид дарагдахааргүй бэхэлгээ хаалт хийх, далд малталтаас ордыг төлөөлөхүйц 20 тонн технологийн дээж бэлтгэх, дээжийг зориулалтын саванд савлаж Улаанбаатар хотод тээвэрлэн авчирах.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]